

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Мандал сумын "Цант Орхон" ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/01/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn
Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом аудит" ХХК
Утас: 99052418 Цахим хаяг: peakomaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	9
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
4. Аудитын тайлан.....	11
4.1. Ерөнхий зүйл	11
4.2. Материаллаг байдал.....	12
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар	13
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. Аудитын илрүүлэлт	14
Залруулга	14
5.1 Албан шаардлага	15
5.2 Зөвлөмж.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МТА	Монголын татварын алба
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ЦАНТ ОРХОН” ААТҮГ-
ЫН ДАРГА Д.БАТЭРДЭНЭ
ТАНАА

2024.03.15 № САА-2024/01-НН-СТА-000А
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цант Орхон” ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Цант Орхон” ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Цант Орхон” ААТҮГ нь тайлант онд 1,154,792.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,322,132.7 мянган төгрөгийн зардал гарган 167,340.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Алдагдал нь үндсэн үйл ажиллагааны үр дүнгээр бус үндсэн хөрөнгийн дахин үнэлгээнээс голлон шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т борлуулалтын орлого, өртгийн тооцоолол, хөрөнгө оруулалтын талаар нарийвчлан тусгаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Цант Орхон” ААТҮГ-ын 2023 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.0 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	15,603,693,092.21	15,433,550,559.26
1.1	Эргэлтийн хөрөнгө	552,784,301.83	550,571,230.72
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	419,622,839.18	432,066,332.47
1.1.2	Дансны авлага	69,037,441.77	40,138,552.01
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	33,047.00	
1.1.6	Бараа материал	64,090,973.88	78,366,346.24
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	552,784,301.83	550,571,230.72
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	15,049,225,790.38	14,882,484,328.54
1.2.2	Биет бус хөрөнгө	1,683,000.00	495,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	15,050,908,790.38	14,882,979,328.54
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,603,693,092.21	15,433,550,559.26
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	15,603,693,092.21	15,433,550,559.26
2.1	Өр төлбөр	3,099,726.63	297,897.76
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	3,099,726.63	297,897.76
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	3,099,726.63	297,897.76
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,099,726.63	297,897.76
2.2	Өр төлбөрийн нийт дүн	3,099,726.63	297,897.76
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	1,937,114,135.00	1,937,114,135.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14,574,144,861.64	14,574,144,861.64
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(910,665,631.06)	(1,078,006,335.14)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	(156,177,332.61)	(167,340,704.08)
2.3.9	Өмнөх үеийн ашиг	(754,488,298.45)	(910,665,631.06)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	15,600,593,365.58	15,433,252,661.50
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	15,603,693,092.21	15,433,550,559.26

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,078,439,918.35	1,129,352,539.75
2	Борлуулалтын өртөг	1,195,660,456.20	1,277,667,364.25
3	Нийт ашиг (алдагдал)	(117,220,537.85)	(148,314,824.50)
4	Түрээсийн орлого	8,419,090.90	9,456,363.65
5	Хүүний орлого		5,883,213.82
8	Бусад орлого	2,640,243.00	10,099,901.55
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	46,487,910.47	41,029,793.09
12	Бусад зардал	3,528,218.19	483,209.10
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(2,952,356.41)
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(156,177,332.61)	(167,340,704.08)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(156,177,332.61)	(167,340,704.08)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(156,177,332.61)	(167,340,704.08)
24	Орлогын нийт дүн	(156,177,332.61)	(167,340,704.08)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Өмч		Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,917,096,129.00		22,765,404,928.04		(754,488,298.45)	23,928,012,758.59
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	20,018,006.00		(8,191,260,066.40)			(8,171,242,060.40)
3	Залруулсан үлдэгдэл						-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					(156,177,332.61)	(156,177,332.61)
5	Бусад дэлгэрэнгүй орлого						-
6	Өмчид гарсан өөрчлөлт						-
7	Зарласан ногдол ашиг						-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
9	2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,937,114,135.00		14,574,144,861.64		(910,665,631.06)	15,600,593,365.58
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						-
11	Залруулсан үлдэгдэл						-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					(167,340,704.08)	(167,340,704.08)
13	Бусад дэлгэрэнгүй орлого						-
14	Өмчид гарсан өөрчлөлт						-
15	Зарласан ногдол ашиг						-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
17	2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,937,114,135.00	-	14,574,144,861.64	-	(1,078,006,335.14)	15,433,252,661.50

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022оны 12-р сарын 31	2023оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,210,572,128.02	1,294,612,398.14
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,210,572,128.02	1,294,612,398.14
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,199,081,965.02	1,267,656,487.32
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	890,420.00	1,006,250.00
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	10,599,743.00	25,949,660.82
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,037,933,866.05	1,198,146,279.85
	Ажиллагчдад төлсөн	452,831,100.45	486,960,266.05
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	107,478,755.90	142,565,559.65
	Бараа материал худалдан авахад төлсөн	219,337,794.00	260,315,245.00
	Ашиглалтын зардалд төлсөн	73,022,646.83	82,671,877.47
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	52,417,750.00	64,781,300.00
	Татварын байгууллагад төлсөн	112,861,083.87	142,031,981.68
	Даатгалын төлбөрт төлсөн	2,391,300.00	2,275,150.00
	Бусад мөнгөн зарлага	17,593,435.00	16,544,900.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	172,638,261.97	96,466,118.29
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	56,885,000.00	68,924,065.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	56,885,000.00	68,924,065.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(56,885,000.00)	(68,924,065.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(9,700,400.00)	(15,098,560.00)
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
		(9,700,400.00)	(15,098,560.00)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	9,700,400.00	15,098,560.00
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	106,052,861.97	12,443,493.29
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	313,569,977.21	419,622,839.18
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	419,622,839.18	432,066,332.47

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
Орлогын нийт дүн	1,125,641.9	1,154,792.0	-29,150.2	102.6
Цэвэр борлуулалтын дүн	1,105,641.9	1,129,352.5	-23,710.7	102.1
Цэвэр усны борлуулалт	15,000.0	12,986.0	2,014.0	86.6
Бохир усны борлуулалт	896,241.5	966,970.6	-70,729.1	107.9
Халуун усны үйлчилгээний	85,500.0	70,876.8	14,623.2	82.9
Зочид буудал үйлчилгээний орлого	108,900.4	78,519.1	30,381.2	72.1
Бусад орлого	20,000.0	25,439.5	-5,439.5	127.2
Нийт зардлын дүн	1,369,285.7	1,322,132.7	47,153.0	96.6
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,320,761.0	1,277,667.3	43,093.7	96.7
Ерөнхий удирдлагын зардал	42,024.7	41,029.8	994.9	97.6
Үйл ажиллагааны бус зардал	6,500.0	3,435.6	3,064.4	52.9
Цэвэр ашиг алдагдал	-243,643.8	-167,340.7	-76,303.1	68.7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

"Цант Орхон" ААТҮГ нь "Мандал суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, айл өрхөөс гарсан бохир усыг татан авч Монгол улсад мөрдөгдөж буй стандарт, технологийн дагуу цэвэршүүлэн байгальд ээлтэйгээр, нийлүүлж, орон нутагтаа бизнесийн бусад үйл ажлаараа бүрэн тогтворжсон чадварлаг хамт олон болно" гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

"Цант Орхон" ААТҮГ-ын дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийг цэвэр усаар хангах,
- Аж ахуйн нэгж, байгууллагын ахуйн болон технологийн бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх үйл ажиллагаа явуулах,
- Зочид буудал, үсчин гоо сайхан, дулаан гражаар үйлчилж гадаад, дотоод худалдаа эрхлэх,

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал бөгөөд 100.0 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

"Цант Орхон" ААТҮГ нь Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль Нийгмийн даатгалын багц хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТБОНӨХБАҮХА тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хамтын хэлэлцээр зэрэг хуулиудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон гэх мэт.

“Цант Орхон” ААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

Тус байгууллагын “Дотоод хяналт шалгалт”-ын баг нь төсөв төлөвлөгөө, үйлдвэрлэл хангамж, хүний нөөц, архив бичиг хэрэг, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа болон худалдан авалт, хөрөнгө оруулалтын чиглэлээр 25 ажил хийхээр төлөвлөж, бүрэн хэрэгжүүлж тайлагнасан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Цант Орхон” ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“Цант Орхон” ААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий борлуулалтын орлого, өртгийн тооцоолол, хөрөнгө оруулалтын талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Цант Орхон” ААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 170,142.5 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	419,622.8	432,066.3	12,443.5
Авлага	69,037.4	40,138.6	(28,898.9)
Бараа материал	64,091.0	78,366.3	14,275.4
Үндсэн хөрөнгө	15,050,908.8	14,882,979.3	(167,929.5)
Нийт хөрөнгө	15,603,693.1	15,433,550.6	(170,142.5)
Өр төлбөр	3,099.7	297.9	(2,801.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	15,600,593.4	15,433,252.7	(167,340.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	15,603,693.1	15,433,550.6	(170,142.5)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 432,066.3 мянган төгрөг болж 12,443.5 мянган төгрөгөөр өссөн нь 1,294,612.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,282,169.0 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 40,138.6 мянган төгрөг болж 28,898.9 мянган төгрөгөөр буурсан нь шинээр 3,352.6 мянган төгрөгийн авлага үүсэж, сумын онцгой комиссын шийдвэрээр Ковидын үед тусгаарлах байраар ашиглаж байсан байрны түрээсийн төлбөрөөс 24,945.0 мянган төгрөгийг төвлөрүүлснээс голлон шалтгаалсан байна. Авлага дансны үлдэгдлийн 54.2 хувийг Ковидын үеийн байрны түрээсийн авлага, 4,600.0 мянган төгрөгийн буюу 11.4 хувийг эзэн холбогдогч нь нас барсан шалтгаантай, олон жилийн насжилттай найдваргүй авлага эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 78,366.3 мянган төгрөг болж 14,275.4 мянган төгрөгөөр өссөн нь 305,149.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 290,874.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 167,929.5 мянган төгрөгөөр буурсан нь өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 66,391.8 мянган төгрөгийн өргөх станцын бохирын цахилгаан насос, усны нөөцийн сав зэрэг тоног төхөөрөмж худалдан авсан, зочид буудлын дээвэрт их засвар хийсэн болон аймгийн ИТХ-ын 2022 оны 90 дүгээр тогтоолоор 14,723.1 мянган төгрөгийн үнэ бүхий машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгслийг акталж данснаас хассан, тайлант онд 219,598.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон зэргээс шалтгаалсан байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасны дагуу “Цант Орхон” ААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Сэлэнгэ аймгийн Засаг дарга нь “Цант Орхон” ААТҮГ-ын даргатай гэрээ байгуулж 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 1,125,641.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,369,285.7 мянган төгрөгөөр, алдагдлыг 243,643.9 мянган төгрөгөөр тооцож

баталсан бөгөөд хөрөнгө оруулалтын 6 арга хэмжээнд 87,859.7 мянган төгрөг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,154,792.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,322,132.7 мянган төгрөгийн зардал гарган, 167,340.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,154,792.0 мянган төгрөг болж төлөвлөгөөг 29,150.2 мянган төгрөг буюу 102.6 хувиар биелүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,322,132.7 мянган төгрөг болж зардлыг 47,153.0 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар хэмнэсэн нь батлагдсан орон тоогоор ажиллаагүй, хөрөнгө оруулалтын ажлууд бүрэн хэрэгжээгүй зэргээс шалтгаалсан байна.

Тайлант онд 167,340.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь ажил үйлчилгээ, бараа материалын үнийн өсөлт, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас голлон шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.1 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд нүүрс, үртэс, шатахуун, кафены бараа бүтээгдэхүүн худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn цахим сайтад 3 удаа байршуулж, зохион байгуулсан байна. Уг нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүйгээс иргэн О.Саруулбуян, М.Хүрэлбаатар “Ширхэнцэг арвин хайрхан” ХХК, “Шунхлай” ХХК- иудтай шууд гэрээ байгуулан, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

№	Худалдан авах бараа	Тендерийн дугаар	Төсөвт өртөг мян.төг	Шууд гэрээ байгуулсан
1	Нүүрс	ЦОААТҮГ/202304001	42,180.0	О.Саруулбуян, “Ширхэнцэг арвин хишиг” ХХК
2	Шатахуун	ЦОААТҮГ/202304002	50,267.8	“Шунхлай” ХХК
3	Үртэс	ЦОААТҮГ/202304003	33,440.0	М.Хүрэлбаатар
4	Кафены бараа бүтээгдэхүүн	ЦОААТҮГ/202304004	30,252.8	Бусдад түрээслүүлсэн учир худалдан авалт хийгээгүй

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Цант Орхон” ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл

баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд татварын тодорхойлолтоор татварын төрөл бүрээр илүү төлөлттэй байгааг хянаж татварын байгууллагатай тооцоо хийж үлдэгдлийг залруулах, өмнөх оны шийдвэрээр тайлант онд хөрөнгийг данс бүртгэлээс хассан зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Цант Орхон” ААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайланг “Пийк Ом Аудит” ХХК-д 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,195,660.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,956.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Цант Орхон” ААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Байгууллагад бүртгэлтэй суудлын автомашиныг шугам хоолойн эвдрэл гэмтэл, засвар үйлчилгээнээс өөр хэрэгцээнд ашиглахгүй талаар журам боловсруулж мөрдсөн,*
- *Ажилчдад олгодог нормын хувцаснаас өөрөөр бусад дүрэмт хувцсаар жигдрэх явдлыг зогсоосон,*
- *Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,*
- *Удирдлагын гар утасны төлбөрийг байгууллагаас төлөхийг зогсоосон,*
- *Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 19 төрлийн 179 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом Аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 226 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 303,837.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс амралт сувиллын хөнгөлөлт олгосон 1,389.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, баталсан зардлыг хэтрүүлэн зарцуулсан, цалинг үндэслэлтэй тогтоогоогүй, тодорхой бус шагнал олгосноос цалингийн зардлыг хэтрүүлсэн зэрэг 244,233.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, насжилт өндөртэй авлагыг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй, хөрөнгийг зөрүүтэй бүртгэсэн, цахим баримтаар баталгаажаагүй худалдан авалтыг гүйцэтгэсэн зэрэг 58,214.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж зөвлөмж өгөгдсөн байна.

Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 85.9 хувийн биелэлттэй байна.

мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	1,389.3	1	1,389.3	100.0
Албан шаардлага	3	244,233.4	3	244,233.4	100.0
Зөвлөмж	3	58,214.5	2	31,859.5	54.7
Нийт дүн	7	303,837.2	6	277,482.2	85.9

Өмнөх аудитаар насжилт өндөртэй, эзэн холбогдогч нь нас барсан гэх авлагыг барагдуулах арга хэмжээ авах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дараагийн аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны үр дүнгээр бус үндсэн хөрөнгийн дахин үнэлгээнээс шалтгаалан тайлант онд 167,340.7 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн байна. Дараагийн аудитаар хөрөнгийн дахин үнэлгээг үндэслэлтэй тогтоосон эсэх, шаардлагатай бол мэргэжлийн байгууллагад хандан дахин үнэлүүлэх эсэх асуудлыг гүнзгийрүүлэн авч үзэх нь зүйтэй байна.

5. Аудитын илрүүлэлт

Залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах 60,308.6 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Худалдан авсан 5,103.1 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалыг төлбөр хүлээн авагчийн нэрээр бус хамаарал бүхий этгээд, өөр аж ахуйн нэгжийн нэрээр орлого авсан,
2. ХХОАТ-ын тайланд цалингийн санг 55,205.5 мянган төгрөгөөр илүү тусгасан байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 26,935.2 мянган төгрөгийн зөрчил илэрч, 10,422.2 мянган төгрөгийн албан шаардлага, 16,513.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах, залруулах 2 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс санхүүгийн тайланд үлдэгдлээр тайлагнагдсан, эзэн холбогдогч нь тодорхойгүй, нас барсан гэх насжилт өндөртэй 4,600.0 мянган төгрөгийн авлагыг шийдвэрлэх, шаардлагатай бол данс бүртгэлээс хасах талаар арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах..." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

2. Төлбөр тооцоог хянаагүйгээс ХХОАТ-т 5,822.2 мянган төгрөгийг илүү төлсөн боловч татварын байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих," гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж 2024 оны эхний хагас жилд санхүүгийн тайланд залруулга хийх албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

1.Татварын авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: МТА-ны "Байгууллагын татварын тодорхойлолт"-оор татварын төрөл тус бүрээр илүү төлөлттэй гэсэн боловч санхүүгийн тайланд тусгагдаагүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, авлага, өр төлбөрийг үнэн зөв тайлагнах,

2.Хөрөнгө акталсан шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 14,723.1 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах шийдвэр гарсан боловч он дамжуулан 2023 онд акталж данс бүртгэлээс хассан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн

нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг тухай бүр бүртгэж, тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5¹ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
1. Худалдан авсан бараа материалыг төлбөр хүлээн авагчийн нэрээр бус хамаарал бүхий этгээд, өөр аж ахуйн нэгжийн нэрээр орлого авсан	1	5,103.1			1	5103.1	1	5103.1				
2. ХХОАТ-ын тайланд цалинг илүү тусгасан	1	55,205.5			1	55,205.5	1	55,205.5				
Дүн	2	60,308.6			2	60,308.6	2	60,308.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс эзэн холбогдогч нь тодорхойгүй, нас барсан гэх насжилт өндөртэй авлагыг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй	1	4,600.0			1	4,600.0						
2. Төлбөр тооцоог хянаагүйгээс ХХОАТ илүү төлсөн боловч татварын байгууллагатай	1	5,822.2			1	5,822.2						

¹ Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй												
3. МТА-ны "Байгууллагын татварын тодорхойлолт"-оор татварын төрөл тус бүрээр илүү төлөлттэй гэсэн боловч санхүүгийн тайланд тусгагдаагүй, анхан шатны баримтаар нотлогдоогүй	1	1,789.9					1	1,789.9				
4. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг тухай бүр бүртгэж, тайлагнаагүй	1	14,723.1					1	14,723.1				
Дүн	4	26,935.2			2	10,422. 2	2	16,513.0				